



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/131

Мандалговь

Г Агуулахын байршил тогтоох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баянжаргалан сумын нутагт орших "Говь Шоо" ХХК-ний MV-00017543 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг хавсралтаар тогтоосугай.

Хоёр. Тэсрэх материалын агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд хуулийн хугацаанд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чэгнаадорж/-т үүрэг болгосугай.

Гурав. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг мэдээллийн нэгдсэн санд хуулийн хугацаанд бүртгүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200445

Аймгийн Засаг даргын 2018 оны 04  
дүгээр сарын 29-ны өдрийн А/ЗД  
дугаар захирамжийн хавсралт



Тэсрэх материалын агуулахын байнгын байршлын солбилцол

Цэгийн дугаар	X	Y
1.	45° 34' 24"	107° 52' 33"
2.	45° 34' 23"	107° 52' 34"
3.	45° 34' 21"	107° 52' 27"
4.	45° 34' 20"	107° 52' 30"